

“Зоос гоёл”ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны үр дүнгийн тайлан

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2016 онд компанийн дүрэм, бусад хууль журмаар олгосон эрхийн хүрээнд ажилласан байна.

ТУЗ-д нийт 9 гишүүн /үүнд 6 хараат бус, 3 энгийн/ 3 хороо /аудит, нэр дэвшүүлэх, цалин хөлсний/-дод хуваагдан ажилласан болно. Гишүүд нь өөрсдийн хариуцсан үүрэг чиглэлийн дагуу гүйцэтгэх захиралтай нягт холбоотой ажиллаж ирснээс гадна, улирал бүр хуралдаж компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж ирсэн билээ.

Тайлангийн хугацаанд их хэмжээний ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй, урт богино хугацааны зээл аваагүй болно.

Компанийн захиргаа тайлангийн хугацаанд захиргаа, санхүү, борлуулалт, маркетинг, аж ахуй үйлчилгээний алба гэсэн зохион байгуулалттай ажлын байрны 18 орон тоо бүхий бүрэлдэхүүнтэй ажил үүргээ гүйцэтгэж ажиллаа.

Компани түрээслэгч аж ахуй нэгж, хувь хүнтэй 1 жилийн хугацаатай түрээсийн гэрээ байгуулан гэрээний үндсэн дээр оффис, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт бүхий түрээсийн үйл ажиллагаа эрхлэн явуулж, түрээсийн тогтмол орлогоор үндсэн орлогын эх үүсвэрийг бүрдүүлж мөн Ерөнхийлөгчийн тамгын газрын захиалгаар Төрийн одон медаль үйлдвэрлэсэн байна.

2016 он санхүү эдийн засгийн орчин бараа үйлчилгээний үнэ, инфляцийн түвшин зэрэг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шууд нөлөөлөгдөх нөхцөл нь сайнгүй байгаагаас түрээсийн орлого буурч санхүүгийн тайлангийн цэвэр ашиг буурсан үзүүлэлттэй байна. Компанийн санхүүгийн тайланг шалгаж баталгаажуулсан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хараат бус Би Энд Си аудитын компанийг гэрээний дагуу ажиллууллаа. Энэхүү тайлангийн үзүүлэлтэд тулгуурлан үйл ажиллагааны үр дүнг тайлан балансын гол үзүүлэлттэй уялдуулан ТУЗ-ийн аудитын хорооноос дүгнэснийг тодруулбал:

Нэг. Компанийн үндсэн ажиллагаа, орлого үр дүн

Тус компанийн үндсэн ажиллагааны нийт орлого 2016 оны гүйцэтгэлээр 850,216,4 мянган төгрөг болж өмнөх оноос 21,1 сая /2,4%/ төгрөгөөр буурсан. Үндсэн үйл ажиллагааны орлогын 66 хувийг түрээсийн, 34 хувийг одон медалийн борлуулалтын орлого тус бүр эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оноос борлуулалтын орлого 91,5 сая төгрөгөөр нэмэгдсэн боловч түрээсийн орлого 112,6 сая төгрөгөөр буурсан нь түрээслэгчдийн төлбөрийн чадварын бууралттай холбоотой төдийгүй хадгаламжийн хүү болон эрхийн шимтгэлийн орлого өнгөрсөн оноос бараг 2 дахин /52,6 сая төгрөгөөр буюу 44,5 %-иар/ буурч нийт орлогод эзлэх хувийн жин нь эрс багассан байгаа.

Борлуулалтын барааны өртөг өмнөх оноос 61,1 сая төгрөгөөр нэмэгдсэн боловч борлуулалтын орлогод эзлэх хувийн жин нь 3,5%-иар багассан, ерөний удирдлагын зардал 1,7 сая төгрөгөөр буурсан зэрэг эерэг үзүүлэлтүүд байгаа боловч борлуулалтын болон маркетингийн зардал 39,4 сая төгрөгөөр нэмэгдсэн нийт орлогод эзлэх хувийн жин нь 5,9 хувиар нэмэгдсэний нөлөөгөөр үндсэн ажиллагааны ашиг өмнөх оноос бараг 120,0 сая төгрөгөөр /119,9 сая төгрөг буюу 67,2 хувиар/ буурсан нь дээр нэрлэсэн борлуулалтын өртөг болон маркетингийн зардлын өсөлтөөс гадна, түрээсийн орлого буурсантай холбоотой байгаа.

Компанийн дүгнэлтээр тооцоход 2016 онд татварын өмнөх байдлаар 123,5 сая төгрөгийн ашигтай ажилласан боловч ажлын хэмжээ өмнөх оноос 56,7 хувиар /2,3 дахин/ буурсан төдийгүй, орлогын нэг төгрөгт ногдох зардал 2015 онд 71,19 мөнгө байсан нь 2016 онд 86,52 мянга болж нэмэгдсэн, нэг бүр нь 28,800 төгрөгийн нэрлэсэн үнэтэй зарласан энгийн хувьцааны нэгжид ногдох ашиг нь 8,246 төгрөг болж өмнөх оноос 2,3 дахин буурсан байна.

**“Зоос гоёл” ХК-ийн хөрөнгө эх үүсвэрийн зэрэгцүүлэлт
(2015-2016)**

Хүснэгт №1

	2016		2015		Өөрчлөлт	
	мян.төг	х/жин	мян.төг	х/жин	мян.төг	х/жин
Эргэлтийн хөрөнгө						
Мөнгөн хөрөнгө	368,997.5	19.1	351,427.8	18.0	17,569.7	5.0
Авлагын тооцоо	47,482.4	2.5	4,804.5	0.2	42,677.9	-
Бараа материал	62,701.6	3.2	53,122.3	2.7	9,579.3	18.0
Дүн	479,181.5	24.8	409,354.6	21.0	69,826.9	17.1
Эргэлтийн бус хөрөнгө						
Үндсэн хөрөнгө	1,889,173.2	97.6	1,846,606.8	94.7	42,566.4	2.3
Хуримт. элэгдэл	(433,655.0)	(22.4)	(306,904.3)	(15.7)	(126,750.7)	41.3
Бусад хөрөнгө	937.5	0.0	487.9	0.0	449.6	92.2
Дүн	1,456,455.7	75.2	1,540,190.4	79.0	(83,734.7)	(5.4)
Нийт хөрөнгийн дүн	1,935,637.2	100.0	1,949,545.0	100.0	(13,907.8)	(0.7)
Богино хугацаат өглөг						
Дансны өглөг	54,001.1	2.8	23,285.9	1.2	30,715.2	131.9
Тооцооны өглөг	1,987.9	0.1	10,655.1	0.5	(8,667.2)	(81.3)
Ногдол ашгийн өглөг	25,283.2	1.3	11,430.8	0.6	13,852.4	121.2
Зээлийн өглөг						
Дүн	81,272.2	4.2	45,371.8	2.3	35,900.4	79.1
Урт хугацаат зээл төлбөр						
Нийт өр төлбөр	81,272.2	4.2	45,371.8	2.3	35,900.4	79.1
Эзэмшигчийн өмч						
Хуь нийлүүлсэн өмч	375,494.4	19.4	375,494.4	19.3	-	-
-Халаасны хувьцаа	(106,732.8)	(5.5)	(106,934.4)	(5.5)	201.6	(0.2)
Дахин үнэлгээний нөөц	1,073,692.6	55.5	1,073,692.6	55.1	-	-
Өмчийн бусад хэсэг	57,986.7	3.0	56,951.0	2.9	1,035.7	1.8
Хуримтлагдсан ашиг	453,924.1	23.5	504,969.7	25.9	(51,045.6)	(10.1)
Үүнээс: тайлант оны	107,513.4	5.6	253,006.5	13.0	(145,493.1)	(57.5)
Өмчийн дүн	1,854,365.0	95.8	1,904,173.3	97.7	(49,808.3)	(2.6)
Өр төлбөр эздийн өмчийн дүн	1,935,637.2	100.0	1,949,545.1	100.0	(13,907.9)	(0.7)

Хоёр. Компанийн хөрөнгө, санхүүгийн байдал

Компанийн нийт хөрөнгө 2016 оны эцэст 1935,6 сая төгрөг болж өмнөх оноос 13,9 сая төгрөгөөр /0,7 хувиар/ эзэмшигчийн өмчийн дүн 49,8 сая төгрөгөөр /2,6 хувиар/ тус бүр буурсан байна.

Хөрөнгийн бүрэлдэхүүний хувьд эргэлтийн хөрөнгийн дүн 69,8 сая төгрөгөөр нэмэгдэж, түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хувийн жин өсөн, харин эргэлтийн бус хөрөнгийн дүн тайлант онд байгуулсан элэгдлийн хэмжээгээр багассан эерэг өөрчлөлт гарчээ. Оны эцсийн байдлаар нийт хөрөнгийн 20 гаруй хувь, эргэлтийн хөрөнгийн 86,9 хувь нь түргэн хөрвөх хөрөнгүүд байгаа нь эдгээр хөрөнгийг оновчтой байршуулж, эргэлтэнд оруулахын хирээр орлого, ашгийг нэмэгдүүлэх боломжтойг илтгэж байна.

Тайлант онд богино хугацаат өрийн дүн 35,9 сая төгрөгөөр нэмэгдсэний 13,8 сая төгрөг нь ногдол ашгийн өглөгийн өсөлт байгаа нь хувьцаа эзэмшигчдийн идэвхи оролцоо хангалтгүй байгаагийн илэрхийлэл гэж болно.

Эзэмшигчдийн өмчийн дүн 2016 онд 49,8 сая төгрөгөөр буюу 2,6 хувиар буурсан нь 158,6 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилаад, ажиллагааны үр дүнгээр 107,5 сая төгрөгийн ашигтай ажилласантай холбоотой юм.

Бүхэлд нь дүгнэвэл 2016 онд хөрөнгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахаар томоохон худалдан авалт, хөрөнгө оруулалт хийгдээгүй, түргэн хөрвөх хөрөнгийн хувийн жин нэмэгдэх хандлагатай байгаа, нэгэнт бүрэлдсэн санхүүгийн энэ боломжийг илүү санаачлагатай, өгөөжтэй ашиглахыг зөвлөж байна. Тэгэхдээ тус компанийн хөрөнгийн хэмжээ харьцангуй бага, томоохон санхүүжилт хийх боломж хязгаарлагдмал гэдгийг анхаарах ёстой.

Гурав. Ногдол ашиг олголтын байдал

2015 оны цэвэр ашгаас нэгж гаргасан хувьцаанд /хувьцаа нэгтгэх төсөл хэрэгжсэний дараах нэгтгэсэн нэг бүхэл хувьцаанд/ 17,000 төгрөг буюу нийт 158,559.0 мянган төгрөг хуваарилахаар шийдвэрлэснээс 2016 онд 144,058.0 мянган төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд компаниас бэлнээр болон банкны хадгаламжийн дансанд шилжүүлэх замаар олгосон байна. /хүснэгтээс харна уу/ Энэ нь 2015 оны ашгаас олгохоор хуваарилсан ашгийн 90.85% болж үлдсэн 9,15% буюу **14,501.0** мянган төгрөгийн ногдол ашгийн үлдэгдэлтэй, харин өмнөх жилүүдийн олгогдоогүй ногдол ашгийн үлдэгдэл 11,430.83 мянган төгрөгөөс 648.58 мянган төгрөгийн ногдол ашгийг нөхөн олгосноор өмнөх жилүүдийн ногдол ашгийн үлдэгдэл **10,782.24** мянган төгрөг болсноор нийт **25,283.24** мянган төгрөгийн ногдол ашгийн үлдэгдэлтэй /2016.12.31-ны байдлаар/ байна. 2015 оны ашгаас хуваарилсан ногдол ашгийн олголтын биелэлт 90,85%-тай байгаа хэдий ч нийт ногдол ашгийн 90,22% эзлэх хоёр хувьцаа эзэмшигч ашгаа бүрэн авсныг хасч үзэхэд нийт ногдол ашгийн 9.78%-ийг авах жижиг хувьцаа эзэмшигчид 0.63%-ийг авснаар гүйцэтгэл үнийн дүнгээр 6.5%, хувьцаа эзэмшигчдийн тоогоор 10.8%-тай байгаа нь хэдийгээр хувьцаа нэгтгэх төсөл хэрэгжиж жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо цөөрсөн ч мөн л хангалтгүй, идэвхгүй хэвээр байгааг харуулж байна.

СЗХ-ноос ногдол ашиг олголт, тараах талаар 2017 оны 1-р сард ирүүлсэн албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ТУЗ-өөс он дамжсан ногдол ашгийн үлдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн ҮЦГХТ-дахь дансанд нь байршуулах замаар ҮЦГХТ ХХК-тай гэрээ байгуулан тараалгах чиглэл өгсний дагуу 2016 оны ашиг тарааж эхлэхээс өмнө буюу 2017 оны 1-р улирлын тайлангаарх дүнд үндэслэн өмнөх жилүүдийн нийт ногдол ашгийн

үлдэгдлийг ҮЦТХТ-д шилжүүлэн тараалгах тооцоо судалгааг, гэрээ байгуулах бэлтгэл ажилд ороод байна. Цаашдаа шинээр хуваарилах ногдол ашгийг мөн хагас жилдээ багтаан компани дээрээс /кассаас бэлнээр болон ХЭ-ийн банкны дансанд шилжүүлэх замаар/ олгогдоогүй ногдол ашгийн үлдэгдлийг тухайн жилийн хагас жилд багтаан ҮЦТХТ ХХК-д шилжүүлж байхаар болсныг үүгээр дуулгаж байна.

Эцэст хэлэхэд 2016 оны цэвэр ашиг 107,51 сая төгрөгөөс компанийн нийт зарласан 13,038 ширхэг энгийн /2015 онд хувьцааг нэгтгэснээр бий болсон/ хувьцаанаас компанийн халаасны 3,704 ширхэг хувьцааг хасч нийт гаргасан **9,334** /10,038-3,704/ ширхэг хувьцаанд нэгж хувьцаанд **6,000** төгрөгийн ногдол ашиг, нийт 56.0 сая төгрөг олгохоор ТУЗ-ийн 2017 оны 17 тоот тогтоолоор шийдвэрлэснийг ХЭХуралд тайлагнан танилцуулж байгаа билээ.

2016 онд ногдол ашиг олголтын тайлан /2016.12.31-ээр/

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	хэмж. нэгж	Өмнөх онуудын НА		2015 оны ашгаас хуваарилсан НА		Нийт /өссөнөөр/		
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь	
Эхний үлдэгдэл /2015.12.31/	дүн	м.төг	11,430.83	100%	-		11,430.83	
	ХЭ-д	тоо	2152	100%	-		2152	
Хуваарилсан /2015он/	дүн	м.төг	-		158,559.0	100%	158,559.0	
	ХЭ-д	тоо	-		372	100%	372	
Нийт олгох	дүн	м.төг			158,559.0	100%	169,989.83	100%
Олгосон НА	дүн	м.төг	648.58	5.68%	144,058.0	90.85%	144,706.58	85.13%
	ХЭ-д	тоо	144	6.69%	40	10.75%	184.00	7.29%
Үүнээс: цөөнх	дүн	м.төг			143,055.0	90.22%	143,055.0	84.16%
	ХЭ-д	тоо			2	0.54%	2	0.08%
Бусад	дүн	м.төг	648.58	68.98%	1,007.0	0.63%	1,655.58	0.97%
	ХЭ-д	тоо	144	6.69%	38	10.21%	182	7.21%
Эцсийн үлдэгдэл /2016.12.31/	дүн		10,782.24	94.32%	14,501.0	9.15%	25,283.24	14.87%
	ХЭ-д		2008	93.31%	332	89.25%	2340	92.71%

Ийнхүү өнгөрсөн оноос манай улсад эдийн засгийн нүүрлэж, мөнгөний ханш унаж, ард иргэдийн худалдан авах чадвар буурч, олон жижиг дунд аж ахуйн нэгжүүд хаалгаа барьж эхэлсэн нь манай компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн хэдий ч компанийн удирдлага, хамт олны хичээл зүтгэлийн үр дүнд чамхааргүй амжилттай ажиллаа гэж ТУЗ-өөс дүгнэсэн бөгөөд ирэх онд илүү хичээл зүтгэл гарган ажиллахыг үүрэг болголоо.

Төлөөлөн удирдах зөвлөл